



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/015/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016 Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан (төгрөгөөр)	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)	6
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр).....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 15 № 135

танай _____ -ны № _____ -т

СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ АЖ
АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ Т.ЭРХЭМБАЯР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 11,379.8 мянган төгрөгийн татварын авлага, 22,863.3 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй;
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтын хуудас, удирдамжгүй 1,451.2 мянган төгрөгийн онгоцны тасалбарын төлбөр шилжүүлсэн;
- Санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн борлуулалтын орлогоос 75,629.1 мянган төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн тайлангийн борлуулалтын орлогоос 20,869.1 мянган төгрөгөөр зөрүүтэй зэрэг зөрчлүүд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7

822511000415

дугаар зүйлийн 7.4, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Говь-Алтай аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор тус газрын дулаанаар зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 жилийн хугацаатай сунгасан байна.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр барилгад 18,499.0 мянган төгрөгийн, халаалтын зууханд 19,500.0 мянган төгрөгийн засвар хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,831,867.6 мянган төгрөгийн, хүүгийн орлогоос 739.3 мянган төгрөгийн, нийт 1,832,606.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт 2,062,250.5 мянган төгрөгийн зардал гарган, 229,643.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус газар нь 5 зорилт, 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Засаг даргаас биелэлтийг 94.1 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	528,948,030.10	735,981,533.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,220,802.40	86,875,461.73
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	37,220,802.40	86,875,461.73
31210	Төгрөг	37,220,802.40	86,875,461.73
31213	Арилжааны банк дахь харилцах	37,220,802.40	86,875,461.73
33	АВЛАГА	240,194,299.54	349,961,888.46
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	18,519,467.61	11,379,775.19
33500	Бусад авлага	221,674,831.93	338,582,113.27
33510	Байгууллагаас авах авлага	219,847,522.19	337,864,611.70
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,827,309.74	717,501.57
34	УРЬДЧИЛГАА	149,001,200.00	149,001,200.00
34600	Урьдчилж гарсан зардал	149,001,200.00	149,001,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	102,531,728.16	150,142,983.12
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,513,272.46	51,936,727.80
35400	Хангамжийн материал	90,018,455.70	98,206,255.32
35410	Бичиг хэргийн материал	904,796.08	989,887.54
35420	Аж ахуйн материал	88,880,150.84	96,982,859.00
35440	Түлш, шатах тослох материал	233,508.78	233,508.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,418,448,784.51	9,186,845,115.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,418,448,784.51	9,186,845,115.63
39200	Биет хөрөнгө	9,378,268,784.51	9,146,845,115.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,432,326,761.10	9,450,825,761.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(852,559,467.24)	1,068,512,536.46
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,215,788,701.61	1,244,485,701.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(419,662,725.96)	(481,979,158.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,918,900.00	3,918,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,543,385.00)	(1,893,552.50)
39300	Биет бус хөрөнгө	40,180,000.00	40,000,000.00
39301	Програм хангамж	960,000.00	960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(780,000.00)	(960,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	9,947,396,814.61	9,922,826,648.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	79,056,506.44	157,591,195.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	79,056,506.44	157,591,195.56
41300	Өглөг	79,056,506.44	157,591,195.56
41360	Бусад өглөг	79,056,506.44	157,591,195.56
41361	Байгууллагад төлөх өглөг	64,142,076.89	126,006,101.76
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	14,914,429.55	31,585,093.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,868,340,308.17	9,765,235,453.38
51	Засгийн газрын хувь оролцоо	9,868,340,308.17	9,765,235,453.38
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	10,589,312,799.10	10,589,312,799.10
51200	Хуримтлагдсан үр дүн	(720,972,490.93)	(824,077,345.72)
51210	Өмнөх үеийн үр дүн	(770,942,593.04)	(720,972,490.93)
51220	Тайлант үеийн үр дүн	49,970,102.11	(103,104,854.79)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	9,947,396,814.61	9,922,826,648.94

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	330,857,791.62	367,187,654.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	330,857,791.62	367,187,654.07
120	Нийтлэг татварын бус орлого	330,857,791.62	367,187,654.07
1201	Хүүгийн орлого	289,624.79	0
120002	Бусад хүүгийн орлого	289,624.79	0

120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	1,707,472,894.60	1,771,495,265.74
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,376,904,727.77	1,404,307,611.67
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280,887,689.51	470,292,508.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,887,689.51	470,292,508.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,887,689.51	470,292,508.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,887,689.51	470,292,508.86
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	246,089,726.54	469,995,692.13
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	28,189,729.37	296,816.73
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,056,000.00	0
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	5,552,233.60	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	49,970,102.11	(103,104,854.79)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	49,970,102.11	(103,104,854.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,806,927,448.40	1,832,606,965.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,806,927,448.40	1,832,606,965.09
120	Нийтлэг татварын бус орлого	1,806,927,448.40	1,832,606,965.09
120009	Бусад орлого	856,543.21	240,769.01
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,806,070,905.19	1,832,366,196.08
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,749,889,735.41	1,736,254,875.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,749,889,735.41	1,736,254,875.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,749,889,735.41	1,736,254,875.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,214,373.00	434,774,973.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	339,214,373.00	434,774,973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,032,031.46	132,359,464.66
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	105,032,031.46	132,359,464.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,509,663.61	242,890,346.21
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	200,509,663.61	242,890,346.21
2104	Хангамж, бараа материалын зардал	930,342,850.00	742,366,650.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	905,158,500.00	715,553,950.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	25,184,350.00	26,812,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,790,817.34	183,863,441.32
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	0
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	138,843,916.08	92,952,506.46
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	35,466,901.26	90,910,934.86
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,037,712.99	96,352,089.90
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0	498,569.43
140007	Хүлээн авсан хүүний орлого	0	498,569.43
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	21,624,981.80	47,196,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,624,981.80	47,196,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,624,981.80	47,196,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,624,981.80	0
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	0	47,196,000.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-21,624,981.80	(46,697,430.57)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	371,713.54	0
230001	Эргэж төлөгдөх зээл	371,713.54	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(371,713.54)	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,041,017.65	49,654,659.33
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,179,784.75	37,220,802.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,220,802.40	86,875,461.73

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,589,312,799.10	(770,942,593.04)	9,818,370,206.06
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,589,312,799.10	(770,942,593.04)	9,818,370,206.06
9	Тайлант үеийн үр дүн	0	49,970,102.11	49,970,102.11
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,589,312,799.10	(720,972,490.93)	9,868,340,308.17
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,589,312,799.10	(720,972,490.93)	9,868,340,308.17
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,589,312,799.10	(720,972,490.93)	9,868,340,308.17
19	Тайлант үеийн үр дүн	0	(103,104,854.79)	(103,104,854.79)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,589,312,799.10	(824,077,345.72)	9,765,235,453.38

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	1,724,862,000.00	1,832,606,965.09	(107,744,965.09)	106.2
Төсөвт байгууллагын халаалтын орлого	1,429,330,000.00	1,356,292,032.20	73,037,967.80	94.9
Аж ахуй нэгж байгууллагын халаалтын орлого	70,416,000.00	148,295,651.26	(77,879,651.26)	210.6
Айл өрхийн халаалтын орлого	225,116,000.00	327,279,943.19	(102,163,943.19)	145.4
бусад орлого		739,338.44	(739,338.44)	
Нийт зардал	1,968,254,000.00	2,062,250,544.07	(93,996,544.07)	104.8
Үйл ажиллагааны зардал	1,628,244,000.00	1,728,334,875.19	(100,090,875.19)	106.1
Бусад зардал	19,913,000.00		19,913,000.00	-
Тэтгэмж,шагнал урамшуулал	3,500,000.00	7,920,000.00	(4,420,000.00)	226.3
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	216,705,000.00	278,799,668.88	(62,094,668.88)	128.7
Хөрөнгө оруулалтын зардал	99,892,000.00	47,196,000.00	52,696,000.00	47.2
Татварын төлөхийн өмнөх ашиг	(243,392,000.00)	(229,643,578.98)	(13,748,421.02)	94.4
Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын зардал			-	
Татварын дараах ашиг	(42,644,951.00)	49,970,102.13	49,970,102.13	(117.2)
Нийт ажиллагсдын тоо	34.00	33.00	1.00	97.1
Нийт цалингийн сан	543,454,000.00	567,134,437.66	(23,680,437.66)	104.4
Мөнгөний үлдэгдэл	400,000.00	86,875,461.73	(86,475,461.73)	21,718.9
Нийт авлага	154,000,000.00	349,961,888.46	(195,961,888.46)	227.2
Нийт өглөг	136,000,000.00	157,591,195.56	(21,591,195.56)	115.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулсан алдаа

Аудитаар 159,344.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Санхүүгийн байдлын тайланд авлагыг 22,117.1 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 7,065.7 мянган төгрөгөөр, өглөгийг 23,085.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Тайланд онд төсвийн хөрөнгөөр барилгад 18,499.0 мянган төгрөгийн, халаалтын зууханд 19,500.0 мянган төгрөгийн засвар хийснийг хөрөнгийн сайжруулалтаар бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 12,602.8 мянган төгрөгөөр илүү, орлогыг 7,524.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, 22,492.0 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчсөн байна.

Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой:

- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 26,458.0 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 35,694.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 35,694.3 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрсэнд 1,451.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, 34,243.1 мянган төгрөгийн 3 зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

3.2 Албан шаардлага

1. Аймгийн ЖДҮДС-аас 2019 онд авсан зээлээр хийсэн шугамын ажлыг хүлээн аваагүй, санхүүгийн байдлын тайланд 149,001.2 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлаар бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 11,379.8 мянган төгрөгийн татварын авлага, 22,863.3 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн тооцоо нийлж, санхүүгийн тайланд залруулах арга хэмжээ авч, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн борлуулалтын орлогоос 75,629.1 мянган төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн тайлангийн борлуулалтын орлогоос 20,869.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах"; гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын орлогыг зөв тайлагнаж залруулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Хөрөнгийн ашиглалттай холбоотой

1. Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны үнийг бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 12 нэр төрлийн 9,655.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай

зөвшилцөн тогтоох;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй хөрөнгийн чанар байдлыг тогтоож байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх

Хоёр. Төсвийн зарцуулалттай холбоотой

2. Илрүүлэлт: Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтын хуудас, удирдамжгүй 1,451.2 мянган төгрөгийн онгоцны тасалбарын төлбөр шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэхгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ	Авлагыг 22,117.1 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 7,065.7 мянган төгрөгөөр, өглөгийг 23,085.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	52,268.3			1	52,268.3	1	52,268.3	-	-	-	-
	Төсвийн хөрөнгөөр барилгад 18,499.0 мянган төгрөгийн, халаалтын зууханд 19,500.0 мянган төгрөгийн засвар хийснийг сайжруулалтаар бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан.	1	37,999.0			1	37,999.0	1	37,999.0	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 12,602.8 мянган төгрөгөөр илүү, орлогыг 7,524.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, 22,492.0 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан.	1	42,619.2			1	42,619.2	1	42,619.2	-	-	-	-
	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 26,458.0 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.	1	26,458.0	1	26,458.0								

Дүн	4	159,344.5	1	26,458.0	3	132,886.5	4	159,344.5	-	-	-	-
-----	---	-----------	---	----------	---	-----------	---	-----------	---	---	---	---

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ	Аймгийн ЖДҮДС-аас 2019 онд авсан зээлээр хийсэн шугамын ажлыг хүлээн аваагүй, санхүүгийн байдлын тайланд 149,001.2 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй.	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны үнийг бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 12 нэр төрлийн 9,655.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.	1	-	-	-	-	-	-	1	-	-
	Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 11,379.8 мянган төгрөгийн татварын авлага, 22,863.3 мянган төгрөгийн өглөгтэй.	1	34,243.1	-	-	1	34,243.1	-	-	-	-
	Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, томилолтын хуудас, удирдамжгүй 1,451.2 мянган төгрөгийн онгоцны тасалбарын төлбөр шилжүүлсэн.	1	1,451.2	-	-	-	-	-	1	1,451.2	-
	Санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн борлуулалтын орлогоос 75,629.1 мянган төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн тайлангийн борлуулалтын орлогоос 20,869.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлангласан.	1	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5	35,694.3	-	-	3	34,243.1	2	1,451.2	-	-	